



**МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас: 26-35-06, Факс: (976-11) 31-81-69,
<http://www.mmhi.gov.mn>

2022.05.18 № 03/1429

танай _____-ны № _____-т

**ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ
ДАРГА О.ЧУЛУУН ТАНАА**

Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох тухай журмыг шинэчлэн боловсруулж Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/87 дугаар тушаалаар баталсан.

Журмыг захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлийн 5828 дугаарт бүртгэсэн тул цаашид тушаалын хэрэгжилтэд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавьж, биелэлтийг хангаж ажиллана уу.

Хавсралт 2 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Т.НАНДИНЖАРГАЛ



1508 05 1024



МОНГОЛ УЛСЫН
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/87

Улаанбаатар хот

┌ Журам шинэчлэн батлах тухай ┐


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журмыг 1 дүгээр, төсвийн тодотголын хүснэгтийг 2 дугаар, төсвийн тодотголын нэгдсэн хүснэгтийг 3 дугаар, жилийн төсөв батлах хүснэгтийг 4 дүгээр, жилийн төлөвлөгөө батлах хүснэгтийг 5 дугаар, сарын ажлын гүйцэтгэлийн хүснэгтийг 6 дугаар, ажлын гүйцэтгэл, зардлын тайлан гаргах хүснэгтийг 7 дугаар, санхүүжилтийн хуваарь гаргах хүснэгтийг 8 дугаар, сарын ажлын гүйцэтгэл нэгтгэх хүснэгтийг 9 дүгээр, шинээр эхлэх төслүүдийн жагсаалт нэгтгэх хүснэгтийг 10 дугаар, архивт тайлан, материал хүлээн авсан мэдэгдлийн загварыг 11 дүгээр, гүйцэтгэсэн ажлын төсвийн нэгтгэлийн хүснэгтийг 12 дугаар хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэ тушаал болон "Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам"-ыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд зохих журмын дагуу бүртгүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргалд үүрэг болгосугай.

3. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Үндэсний геологийн алба /О.Чулуун/-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам /Г.Нандинжаргал/-д тус тус даалгасугай.

4. Энэ тушаалыг баталсантай холбогдуулан Уул уурхайн сайдын 2015 оны "Журам шинэчлэн батлах тухай" 108 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД  Г.ЁНДОН